



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 4/29

Амардалай

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого судлан
бүртгэх комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2, 29.2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор батлагдсан Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ

Нэг. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Л.Золжаргал / Засаг даргын орлогч /

Гишүүд: Х.Оюунчимэг / Нийгмийн бодлогын мэргэжилтэн /

С.Батцэцэг / ЭМТ-ийн эрхлэгч /

Т.Мөнхтуяа / Багийн эмч, эмчлэгч эмч /

Г.Дэжидсүрэн / ХЭХАХМ мэргэжилтэн /

Ш.Должин / ЕБС-ийн эмч /

З.Түвшинтөр / ХХЭ /

Хоёр. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм, холбогдох бусад дүрэм журмын хүрээнд ажил олгогчид үйлдвэрлэлийн осол гарахаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж өгөх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан нөхцлийг тогтоох, судлан бүртгэж дүгнэлт гарган ажиллахыг комиссын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ



4880100086

